



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 19 өдөр

Дугаар А/200

Булган сум

**“Харилцан Хүндэтгэе” аяныг зохион байгуулахад
хөрөнгө гаргах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.6, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоол, 2025 оны XII хуралдааны “Булган аймгийн 2026 оны төсөв батлах тухай” XII/90 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2026 оны “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардал батлах тухай” А/97 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үндэсний хэмжээнд өрнүүлж буй Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн өдрийг угтан “Хайраа хайрлая, хандлагаа өөрчилье, хамтдаа үлгэрлэе” уриан дор “Харилцан хүндэтгэе” аяныг иргэд олон нийтэд сурталчлан таниулах ажлыг орон нутгийн хэмжээнд үр дүнтэй зохион байгуулсугай.

2. “Харилцан хүндэтгэе” аяны хүрээнд “Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллага, хууль зүйн салбарын эмэгтэйчүүдийн нэгдсэн чуулга уулзалт, зөвлөгөөн, сургалт”-ыг зохион байгуулахад шаардагдах 300,000 (гурван зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хуулийг хэрэгжүүлэх хөтөлбөр” хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газар (Д.Эрдэнэбилэг)-т зөвшөөрсүгэй.

3. “Харилцан хүндэтгэе” аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ДҮРЭВ-ОЧИР



6326010266

Аймгийн Засаг даргын 2026 оны
03 дугаар сарын 19-ны/ний өдрийн
Х.200 дугаар захирамжийн хавсралт

“Харилцан Хүндэтгэе” аяныг зохион байгуулахад
шаардагдах төсөв

д/д	Шаардагдах зардал	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	2	3	4	5
1	“Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллага, хууль зүйн салбарын эмэгтэйчүүдийн нэгдсэн чуулга уулзалт, зөвлөгөөн, сургалт” зохион байгуулах бэлтгэл ажил хангах	-	300,000	300,000
Нийт дүн			300,000	

--o00o--